




172 Page



173 Page



174 Page

СОЛОМОН

- Solomon -

Тайлбарлагч Израилийн хаан Соломон эцэг Давид хаан шигээ Бурханд хайртай нэгэн байлаа. Тэр үед Израильд, Бурханд зориулж барьсан өргөө байхгүй байв. Тиймээс ард түмэн өндөрлөг газар дээр гарч Бурханд мөргөл өргөдөг байлаа. Соломон хаан Гибеед мөргөл өргөхөөр иржээ. Тэнд мянган удаа тахил өргөхөд, Бурхан өргөлийг баяртайгаар хүлээн авсан.

Нэгэн өдөр Соломон хааны зүүдэнд Бурхан үзэгджээ.

Бурхан "Соломон, чи юу хүсэж байна вэ?"

Соломон "Надад ард түмнээ удирдаж чадах мэргэн ухааныг өгөөч"

Тайлбарлагч Бурхан Соломон хааны хүсэлтийг сонсоод маш их баярлажээ.

Бурхан "Чи надаас урт нас, эд хөрөнгө гуйлгүй, мэргэн ухааныг хүссэнд, чиний хүссэний дагуу мэргэн ухаан, ялгах чадварыг өгье. Чамтай адил хүн, чиний өмнө байгаагүй, чиний дараа ч гарч ирэхгүй юм."

Тайлбарлагч Ийнхүү Соломон хаан, олон хэцүү асуудлын учрыг тайлж чаджээ. Нэгэн өдөр хоёр эмэгтэй нэг хүүг тэврээд хаан дээр ирэв.

Эмэгтэй 1 "Бид нэг гэрт амьдардаг. Гэтэл өчигдөр шөнө тэр эмэгтэйн хүү үхчихсэн.

Тайлбарлагч Тэр эмэгтэй уйлан дахин хэлэв.

Эмэгтэй 1 "Гэтэл намайг унтаж байх хооронд үхсэн хүүгээ миний хүүгээр солиод, тавьчихсан байсан. Би хүүгээ эргүүлж авмаар байна. Надад туслаач!"

Тайлбарлагч Харин нөгөө эмэгтэй уйлан байж ингэж хэллээ.

Эмэгтэй 2 "Тэр эмэгтэй худлаа ярьж байна. Өөрөө хүүхдээ дарж алчихаад, миний хүүг авах гэж оролдож байна. Түүний ярьсан бүхэн худлаа."

Тайлбарлагч Хоёр эмэгтэй амьд үлдсэн хүүг өөрийнхөө хүү гэж булаацалдаж байлаа.

Тайлбарлагч Соломон хаан бодож байгаад, Бурханы өгсөн мэргэн ухаанаар ийм шийдвэрийг гаргажээ.

Соломон "Намайг сонс! Маш том сэлэм аваад ир!"

Түшмэл "За, энд аваад ирлээ."

Тайлбарлагч Түшмэл, Соломон хаанд сэлэм авчирч өгчээ. Соломон хаан түшмэлд ингэж хэлэв.

Соломон "Энэ хүүг хоёр хэсэг хуваа. Тэгээд нэг талыг нь тэр эмэгтэйд нөгөө талыг нь нөгөө эмэгтэйд өг" гэжээ.

Тайлбарлагч Хүмүүс ихэд гайхжээ. Гэтэл нэг эмэгтэй нь уйлан ингэж хэлэв.

Эмэгтэй 1 "Үгүй ээ, хүүг амьд үлдээгээч! Хүүг хуваасны оронд тэр эмэгтэйд өг дөө" гэжээ.

Тайлбарлагч Харин нөгөө эмэгтэй ингэж хэлжээ.



175 Page

Эмэгтэй2 “Тэг, тэг. Хоёр хэсэг хуваагаад өг! Миний ч хүү биш, тэр эмэгтэйн ч хүү биш. Хуваатугай!”

Тайлбарлагч Хэсэг хугацааны дараа, Соломон хаан эцсийн шийдвэрийг гаргажээ.

Соломон “Хүүг амьд үлдээгээч гэж гуйж байгаа эмэгтэйд өг! Тэр эмэгтэй бол хүүг төрүүлсэн эх нь мөн!”

Тайлбарлагч Хүү өөрийнхөө жинхэнэ ээждээ тэврүүлжээ. Бүх хүн Соломон хааны мэргэн ухааныг гайхаж байлаа. Соломон хаан Бурханы өгсөн мэргэн ухаанаар асуудлыг сайн шийдэж чадаж байлаа.

Тайлбарлагч Соломон хаан, улс орноо мэргэн ухаанаар, амар тайван дотор үнэхээр сайн удирдан захирч байв. Түүний тухай яриа газар сайгүй тархжээ. Олон хүн Соломон хаантай уулзаж аливаа асуудлаа шийдүүлдэг байлаа. Холын орон болох Шебагийн хатан хаан хүртэл алт, мөнгө, эрдэнэс, анхилуун үнэртэнг ихээр бэлдэж тэмээнд ачаад Соломон хаантай уулзахаар иржээ. Тэгээд мэргэн ухааныг эрэн хайж Израиль хүртэл хол зам туулж ирсэн тэрээр Соломон хаанаас ингэж асуужээ.

Хатан хаан “Энэ дэлхий дээрх хамгийн чухал зүйлийг юу гэж бодож байна вэ?”

Тайлбарлагч Соломон огтхон ч эргэлзэлгүйгээр хариулжээ.

Соломон “Энэ дэлхий дээрх хамгийн чухал зүйлийг мэргэн ухаан гэж боддог.”

Тайлбарлагч Шебагийн хатан хаан маш олон зүйлийг асуухад тэр болгонд Соломон хаан хариулжээ. Шебагийн хатан хаан Соломон хааны мэргэн ухааныг хараад сэтгэл нь ихэд хөдөлжээ. Тэгээд түүнд мэргэн ухаан өгсөн, Бурханыг магтан алдаршуулаад өөрийнхөө авчирсан бэлгийг Соломон хаанд өгчээ.

Тайлбарлагч Соломон хаан ариун өргөөг барих ажлыг эхлүүлжээ. Ливанаас хамгийн сайн модыг авчруулав. Ард түмэн чулуу ба модыг бэлдэцгээв. Ийнхүү Израиль ард түмний хайраар тэрээр долоон жилийг ариун өргөө барих ажилд зориулжээ. Бурханд зориулж барьсан ариун өргөөний ажлыг дуусгасандаа, Соломон хаан их баяртай байлаа. Соломон бүх ард түмнийг цуглуулан хамтдаа ариун өргөөг Бурханд өргөжээ.

Соломон “Өө, Бурхан минь! Танд маш их баярлалаа. Бурханыг алдаршуулан магъя”

Тайлбарлагч Соломон хаан үргэлжлүүлэн Бурханд ийнхүү залбирав.

Соломон “Израилийн Бурхан ЭЗЭН минь ээ, дээд тэнгэр ба доод газарт Тантай адил Бурхан үгүй билээ. Одооноос эхлэн Таны ард түмэн энэ газраас Танд залбирах болно. Бидний залбирлыг Та сонсож, хариулаач. Хэрэв бид гэм үйлдэн түүнээсээ эргэх үедээ энэ газраас Танд хандан залбирахад Өөрийн орших газар болох тэнгэрээс гуйлтыг минь сонсон өрөвдөн уучлаач!”

Тайлбарлагч Соломон хаан хоёр гараа өндөрт өргөөд ард түмнээ ерөөв.



176 Page